



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

2023 оны 01 сарын 30 өдөр

Дугаар E/03

Төрийн сэдүүн, Улаанбаатар хот

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШТАР ТАНАА**

Хуульд хориг тавих тухай

Монгол Улсын Их Хурлаас Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хуулиудыг 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр эцэслэн баталж, Монгол Улсын Их Хурлын дарга 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 16.50 минутад ёсчлон, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр ТГ-01/126 дугаар албан бичгээр ирүүлсэн хуулийг хүлээн авч танилцлаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг тус тус үндэслэн Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хуулиудад дараах үндэслэлээр бүхэлд нь хориг тавьж байна.

Нэг. Монгол Улсын Засгийн газар 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлсэн бөгөөд Монгол Улсын Их Хурал уг хуулийн төслийг хэлэлцэж эхэлснээс хойш хоёр өдөрт багтаан эцэслэн баталжээ.

Хуулийг төслийг боловсруулах, хэлэлцэн батлах үйл явцад иргэн, олон нийтийн оролцоог хангаагүй, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх этгээд, төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагаар хэлэлцүүлж, саналыг аваагүй нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Иргэд, бусад байгууллага хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид уламжилна.", Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5, 8.1.6 дахь заалт, 38 дугаар зүйлийг тус тус зөрчсөн байна.

2023000008

Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Ардчилсан ёс, . . . үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь териин үйл ажиллагааны үндсэн зарчим мөн." хэмээх заалтыг зерчих нөхцлийг бий болгосон байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бурдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зерчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." хэмээн заасан.

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй." хэмээн Үндсэн хуулиар хязгаарлалт тогтоосныг анхаарч байх ёстой.

Тиймээс хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой аливаа хууль тогтоомжийг боловсруулах, хэлэлцэн батлахдаа олон нийтийн оролцоог сайтар хангаж, мэргэжлийн болон судалгааны байгууллагын санаа бодлыг сонсож, олон улсын сайн туршлага, судалгаа шинжилгээнд суурilan Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх зарчмыг чанд баримталж байх учиртай.

Хоёр Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-т "Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих." хэмээн Монгол Улсын Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрхэд заасан байдаг.

Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5 дахь хэсэгт "Энэ хуулийн 45.4-т заасны дагуу илгээсэн хууль, тогтоолыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар хүлээж авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Монгол Улсын Ерөнхийлөгч тухайн хууль, тогтоолыг бүхэлд нь буюу түүний зарим хэсэгт хориг тавих эсэх асуудлыг шийдвэрлэнэ." гэж заасан.

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай болон түүнийг дагалдан батлагдсан нэр бүхий хуулиудын дагаж мөрдөх хугацаа 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдөр байхаар хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн холбогдох хэсгүүдийг зөрчиж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг тавих эрхийг хязгаарласан байна.

Иймд энэхүү хоригийг зохих хууль тогтоомжид заасан журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэх нь зүйтэй хэмээн үзэж байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ

